



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:

ХӨА-2023/223/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум

2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317

Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662

Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400

Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт	11
5.2 Албан шаардлага	11
5.3 Зөвлөмж	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.15 № 01/66
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.РАДНААБҮД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Халамжийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт санхүүгийн тайлангийн дараах үйл явдал болох өмнөх онд хамаарах халамжийн өглөгийн бүртгэл, тайлагналын талаар дурдаагүй байна. Энэ нь халамжийн өглөгийн бүртгэлийг УСНББОУС-ын дагуу аккруэл сууриар бүртгэж, тайлагнах асуудалд эрсдэл учруулж байна.

Аудитын гол асуудал

Халамжийн сангийн үйлчилгээнүүдийн бүртгэлийг 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс Е-халамж цахим программд шилжсэн байна

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн төсвийн шууд захирагч Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг тайлагнасан боловч үнэлгээг хараахан гаргаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ТӨГРӨГӨӨР/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	0	0
.	АВЛАГА	0	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	0	0
.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	0	0
510301	Өмнөх үеийн үр дүн	0	0
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	31,012.69	0
510302	Тайлант үеийн үр дүн	0	0
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	-31,012.69	0
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	0	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	0	0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	962,596,000.00	962,596,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	0	0
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	962,596,000.00	962,596,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	84.33	0
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	84.33	0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	962,596,084.33	962,596,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [11]+[12]+[13]+[14]	0	0
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	2,748,177.02	50,840.00
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	0	0
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	2,748,177.02	50,840.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	959,878,920.00	962,545,160.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	104,400,000.00	90,000,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	50,761,500.00	14,992,950.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	804,717,420.00	857,552,210.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	959,878,920.00	962,596,000.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	-31,012.69	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	962,596,000.00	962,596,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	0	0
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	962,596,000.00	962,596,000.00
1401	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10]	84.33	0
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	962,596,084.33	962,596,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [13]+[14]+[15]+[16]	0	0

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[38]	959,878,920.00	962,545,160.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	104,400,000.00	90,000,000.00
2701023000	ОНОТ үшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	50,761,500.00	14,992,950.00
2702020308	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	0	0
2702026000	Цааган иргэдийн мөнгөн тэтгэмж	804,717,420.00	857,552,210.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	2,748,177.02	50,840.00
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	2,748,177.02	50,840.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	962,627,097.02	962,596,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [11]-[56]	-31,012.69	0
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [60]-[59]	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	31,012.69	31,012.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	31012.69	31012.69
7	Тайлант үеийн үр дүн	0	0	-31,012.69	-31,012.69
8	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0	0
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
14	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
15	2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]	962,596,000.00	962,545,160.00	50,840.00	99.99
6	Халамжийн сан	947,596,000.00	947,552,210.00	43,790.00	99.99
7	Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж	0	0	-	0
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	15,000,000.00	14,992,950.00	7,050.00	99.95
20	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	962,596,000.00	962,545,160.00	50,840.00	99.99
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Эрхэм зорилго: “Төрөөс баримталж буй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн бодлого зохицуулалтыг нягт уялдуулж, хууль журам, ёс зүйг баримтлан, төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чанартай, шуурхай хүргэнэ.” эрхэм зорилгыг удирдлага болгон төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих гэсэн зарчмыг баримтлан “Халамж хүртэгчээс - Баялаг бүтээгч” гэсэн алсын хараагаар зорилгоо амжилттай хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн зорилго нь “Төрөөс баримталж буй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн бодлого зохицуулалтыг нягт уялдуулж, хууль журам, ёс зүйг баримтлан, төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чанартай, шуурхай хүргэнэ” гэсэн байна.

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж
2. Халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээ /цаатан иргэдийн тэтгэмж/
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Тайлант хугацаанд дээрх тэтгэмж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын Захиргаа хяналтын хэлтэс нь Халамжийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ХХҮЕГ-аас 2022 онд Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны А/174 тоот тушаалаар шинэчлэн баталж, мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийг 0 дүнтэй тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	0	0	
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	0	

Дээрх хүснэгтээс харахад, Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь бараа материал, үндсэн хөрөнгө эзэмшдэггүй бөгөөд тайланд онд авлага, өглөг үүсгээгүй ажилласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,124,076.0 мянга төгрөг, нийт зарлагыг 1,124,076.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналыг Сангийн яам хянаж аймгийн ТЭЗ-аас 2022 оны төсвийг 962,560.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь аймгийн төсвийн орлого хүрэлцэхгүй байгаагаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 962,560.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 962,560.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 50.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 962,545.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 50.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80709	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	90,000.0	90,000.0	-	100.0
80712	Халамжийн бусад үйлчилгээ /цаатны тэтгэмж/	857,596.0	857,552.2	43.8	99.9
80708	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	15,000.0	14,992.9	7.1	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн дансгүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 19,251.9 мянган төгрөг гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 962,596.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,251.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой ажил гүйлгээ гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллээс 30 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 –т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь оруулж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил гараагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар алдаа зөрчил гараагүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тайлангийн дараа өмнөх оны халамжийн мөнгийг олгосон эсэхийг хянаж, санхүүгийн тайлан тодруулгад туссан эсэхийг анхаарах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,606.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,606.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нийт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил² илэрснээс, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөөгүй

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллээс 30 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 –т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ..." заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цаатан иргэдэд олгох тэтгэмжээс олгох 3,606,000 төгрөгийг дараа онд нөхөн олгосон боловч санхүүгийн тайланд нэмж тодруулаагүй байна.	1	3,606.0			1	3,606.0	1	3,606.0				
Дүн	1	3,606.0			1	3,606.0	1	3,606.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллээс 30 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна.	1							1
Дүн	1							1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1							1

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХИЙСЭН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХИЙСЭН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
АУДИТОР:

С.ГАНСҮХ ОГНОО:

